



МОНГОЛ  
АРДЫН НАМЫН  
ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2018 оны 08 сарын 03 өдөр

Дугаар: 13

Улаанбаатар хот

**Хариуцлага тооцож ажиллах тухай**

"60 тэрбумын" гэх асуудалд холбогдсон Монгол Ардын Намын гишүүн Ц.Сандуй, А.Ганбаатар, М.Энхболд нарт ёс зүйн хариуцлага тооцож өгнө үү гэсэн Монгол Ардын Намын нэр бүхий гишүүдээс ирүүлсэн хүсэлтийг Монгол Ардын Намын Хяналтын Ерөнхий Хорооны хуралдаанаар хэлэлцээд **ТЭМДЭГЛЭХ НЬ:**

2014 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр Нийслэлийн Монгол Ардын Намын хорооны дарга асан Ц.Сандуй болон Нийслэлийн Монгол Ардын Намын хорооны тэргүүлэгч, намын хорооны даргын санхүүгийн асуудал хариуцсан зөвлөх А.Ганбаатар нарын ярьсан гэх дүрс бичлэг 2016 оны 6 дугаар сарын сүүлчээс эхлэн хэвлэл мэдээлэл болон олон нийтийн сүлжээнд цацагдсан байна. Дээрх бүх мэдээ, мэдээлэл, дүрс, дуу бичлэгийн гол агуулга нь 2016 оны сонгуулийн дараа Монгол Ардын Нам хэрхэн мөнгө босгох талаарх ярилцлага байсан гэх бөгөөд зөвхөн нийслэлийн төр захиргааны байгууллагын ажилтнуудын томилгооноос 60 тэрбум төгрөг босгох боломжийн талаар ярьсан гэжээ.

Нийслэлийн Монгол Ардын Намын хорооны дарга асан Ц.Сандуй энэ талаар ярьсан нь үнэн, бичлэг алдагдсан гэж хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн, мөн Нийслэлийн Монгол Ардын Намын хорооны тэргүүлэгч, намын хорооны даргын санхүүгийн асуудал хариуцсан зөвлөх А.Ганбаатар дээрх яриа болсон талаар хариу тайлбар өгсөн зэргээс үзэхэд "60 тэрбумын" гэх яриа болсон гэдэг нь батлагдаж байна.

Монгол Ардын Намын гишүүн М.Энхболд дээрх "60 тэрбумын" гэх асуудлыг "Хууль хяналтын байгууллагаар шалгуулж, бодит байдалд ийм зүйл болоогүй гэдгээ удаа дараа олон нийтэд мэдээлж байсан төдийгүй Монгол Ардын Намын даргаар

ажиллаж байхдаа болон өнөөдөр ч хэн нэгнээс мөнгө авч албан тушаалд томилсон үйлдэл гаргаагүй.

Энэ зохиомол хэрэгт нэр холбогдон намынхаа нэр хүндийг асуудалд холбогдуулсандаа харамсаж байна." гэж Хяналтын Ерөнхий Хороонд бичгээр илэрхийлсэн байна. Дээрх нэр бүхий 3 гишүүний тайлбар, хүсэлт зэргийг авч үзэхэд Монгол Ардын Намын гишүүн Ц.Сандуй, А.Ганбаатар, М.Энхболд нар ёс зүйн алдаа гаргаж Монгол Ардын Намын ёс зүйн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.4, 2.5, 2.7, 2.8 дахь заалтыг зөрчсөн байна. МАН-ын Удирдах Зөвлөлийн гишүүн М.Энхболд ёс зүйн алдаагаа ухамсарлаж байгааг тэмдэглэв.


Монгол Ардын Намын дүрмийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.2, 33.8, 34 дүгээр зүйлийн 34.1.1, 34.1.4, 34.1.8 дахь заалт, 35 дугаар зүйлийг тус тус үндэслэн намын гишүүдээс ирүүлсэн хүсэлт болон 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн Хяналтын Ерөнхий Хорооны дэргэдэх Ёс зүйн хорооноос гаргасан дүгнэлтийг хэлэлцээд Хяналтын Ерөнхий Хорооны хуралдаанаас **ТОГТООХ НЬ:**

1. Монгол Ардын Намын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2.5, 4.2.6, 4.2.8, 4.2.9 дэх заалтыг зөрчиж, ёс зүйн алдаа гаргасан Монгол Ардын Намын гишүүн М.Энхболдын асуудлыг Монгол Ардын Намын Удирдах Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, хариуцлага тооцон, цаашид Монгол Ардын Намын гишүүдийн зүгээс энэ асуудлыг дэврээж хандахгүй байхыг намын бүх шатны байгууллагад чиглэл болгохыг Монгол Ардын Намын Ерөнхий нарийн бичгийн дарга /Д.Амарбаясгалан/-д даалгасугай.
2. Монгол Ардын Намын гишүүн Ц.Сандуй нь Монгол Ардын Намын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2.5, 4.2.8, 4.2.9 дэх заалтыг зөрчиж ёс зүйн алдаа гаргасан байх тул Монгол Ардын Намын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.4, 4.5 дахь заалтад заасан хариуцлагыг тооцож ажиллахыг Монгол Ардын Намын Ерөнхий нарийн бичгийн дарга /Д.Амарбаясгалан/-д даалгасугай.
3. Монгол Ардын Намын гишүүн А.Ганбаатар нь Монгол Ардын Намын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2.5, 4.2.9 дэх заалтыг зөрчиж алдаа гаргасан байх тул Монгол Ардын Намын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.4, 4.5, 6 дугаар зүйлийн 6.6 дахь заалтад заасан хариуцлагыг тооцохоор Нийслэлийн намын хорооны Тэргүүлэгчдийн хуралд



оруулж хэлэлцүүлэхийг Нийслэлийн Монгол Ардын Намын хороо /С.Батболд/-нд, Нийслэлийн Монгол Ардын Намын хяналтын хороо /О.Оюун/-нд үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг Монгол Ардын Намын Хяналтын Ерөнхий Хороонд 2018 оны III улиралд багтаан танилцуулахыг Монгол Ардын Намын Ерөнхий нарийн бичгийн дарга /Д.Амарбаясгалан/, Нийслэлийн Монгол Ардын Намын хороо /С.Батболд/-нд, Нийслэлийн Монгол Ардын Намын хяналтын хороо /О.Оюун/-нд тус тус даалгасугай.

Дарга  
Гишүүн



Д.БАТБААТАР  
Т.БААСАНЦОГТ  
Ш.АЛТАНЧИМЭГ  
Л.БАТСҮРЭН  
Б.БАТТУШИГ  
Х.БОЛДМАНДАЛ  
Х.ГЭРЭЛТ-ОД  
Л.ДАШМЯГМАРЖАВ  
Л.ДОНДОГ



Ч.НАРАНТУНГАЛАГ  
Ц.СҮХБААТАР  
Ц.СҮХБААТАР  
Ц.ТӨМӨРХҮҮ



О.ОЮУН *О.Оюун*  
Л.ЦЭНГҮҮНЖАВ

